



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

1099 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/348

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.1.5, 7.1.6 Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 02 -ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021-2022 оны хичээлийн жилд Их Засаг олон улсын их сургуулийн “Шилдэг 500 оюутан” -ы нэгээр шалгарч амжилттай суралцсан Сайнцагаан сумын иргэн Түвшинжаргалын Мөнхжаргалын сургалтын төлбөрт 2,000,000 төгрөг, Москвагийн Ардын Найрамдлын их сургуульд тэтгэлгээр 5 жил үнэ төлбөргүй сурах эрхээр шагнагдсан Сайнцагаан сумын иргэн Батболдын Баяндоржид Оросын холбооны улсад суралцахад нь 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111162